Эцэг эх, хуухдіійн хоороыдын
эрхийн харклцаа

Гучин дөрөвдугээр зуйл

1. Хуухдийн эцэг мөн эсэх, тэр гэрлэлтээс хуухэд төрс-
нийг тогтоохдоо хуухэд төрөх уед харъяат нь байсан Хэлэлцэн
Тохирогч Этгээдийн хуулийг баримтлан. шийдвэрлэнэ.

2. Хэлэлцэн Тохирогч нэг Этгээдийн нутаг дэвсгэрт тэд-
•ний хууль тогтоошкоор эцэг мөн болохыг хулээн зөвшөөрсөн
бол хэлбэрийн хувьд зуйтэй гэж узнэ.

Гучин тавдугаар зуйл

Эцэг эх, хуухэд туунчлэн гэрлээгуй уед горсэн хуухэд, тууний эцэг, эхийн хоорондох эрхийн харилцааг уг хуухдийг харьяалах Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хуулиар.тогтооно-

Гучин зургадугаар.зуйл

Гэрээкий 34, 35-р зуйлд дурдсан эрхийн харилцааг хуух-
дийг харьяалах Хэлэлцэн Тохирогч Этгээдийн шуух, эсхул ну-
таг дэвсгэрт нь хуухдийн байнга буюу тур оршин суугаа Хэлэл-
цэн Тохирогч Этгээдийн шуухийн аль, аль нь шийдвэрлэх эрхтэй.

Іочлэлт

Гучин долдугаар зуйл

I. Хуухэд урчлэн авах, туунийг хучингуй болгохдоо урч-
лэн авагчийн харьялагдах Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хуу-
лиар зохицуулна,

2« Хуухэд нь Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн харьяат бол туунийг урчлэн авах буюу хучингуй болгохдоо уг хуухдийг харьяалах Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хуулийн дагуу хууль